НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 02 сарын 05 өдөр Дугаар 09 Улаанбаатар хот

Нийслэлийн өмчид 5 барилга байгууламж
бүртгэн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01/265 дугаар албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Нийслэлийн Баянгол, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгө оруулалт, төрийн өмчийн концессын "Барих-шилжүүлэх" төрлөөр тус тус баригдаж ашиглалтад орсон нийт 21,042,310,846.78 /хорин нэгэн тэрбум дөчин хоёр сая гурван зуун арван мянга найман зуун дөчин зургаан төгрөг далан найман мөнгө/ төгрөгийн өртөг бүхий хавсралтад дурдсан 5 барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Д.Сумъяабазар/-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

ДАРГА Ж.БАТБАЯСГАЛАН

1110100017

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 02 дугаар сарын
05-ны өдрийн 09 дүгээр тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ 5 БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	73 дугаар сургуулийн барилга	Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, Тээвэрчдийн гудамж	2017	10,687,607,034.78	Улсын төсвийн хөрөнгө концессийн "Барих-шилжүүлэх" төрөл
2	143 дугаар сургуулийн барилга	Сонгинохайрхан дүүрэг 23 дугаар хороо	2019	5,674,048,657.00	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
3	55 дугаар цэцэрлэгийн барилга	Сонгинохайрхан дүүрэг 18 дугаар хороо, Үйлдвэрчний эвлэлийн гудамж	2019	2,188,431,012.00	
4	269 дүгээр цэцэрлэгийн барилга	Сонгинохайрхан дүүрэг 5 дугаар хороо	2020	1,314,901,707.00	
5	272 дугаар цэцэрлэгийн барилга	Сонгинохайрхан дүүрэг 1 дүгээр хороо	2020	1,177,322,436.00	
НИЙТ ДҮН				**21,042,310,846.78**	